



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл Мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/55/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7000-3775
Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭРГЭЛЭН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА. Б.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Сэргэлэн сумын сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Тайлант хугацаанд төрийн сангийн мэргэжилтэн гарын үсэг зурж баталгаажуулаагүй, 1-р гарын үсэг тамга тэмдэггүй ажил гүйлгээ хийж бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдлийг бүрэн тооцож бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 14.4. дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.6. дахь "бүх зардал;" гэсэн заалтуудыг зөрчиж байгаа бөгөөд УСНББОУС 3.66-д "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр



Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл Мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

элэгдүүлнэ” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв

байдал, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НЭМ	Нийгмийн эрүүл мэндийн төв

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12

Аудитын тайлан

2.1. Оршил

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн төвийн дарга Б.Золжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 22-ноос 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар-т 2020 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь “Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй чанартай үзүүлэх амьдралын баталгааг хангахад оршино” гэж тодорхойлжээ

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг хүн амд хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “AXPLOERER” программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 322,031.9 төгрөгөөс тооцон 6,440.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг мөн 6,440.6 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,028.7 мянган төгрөгөөр буюу 2,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага			-
Урьдчилгаа			-
Бараа материал	19,088.2	24,081.0	4,992.8
Үндсэн хөрөнгө	400,287.9	416,927.8	16,639.9
Хуримтлагдсан элэгдэл	(48,738.5)	(60,342.5)	(11,604.0)
Нийт хөрөнгө	370,637.6	380,666.3	10,028.7
Өр төлбөр		-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	370,637.6	380,666.3	10,028.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	370,637.6	380,666.3	10,028.7

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материалын дансанд 3752,0 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгслийг орлогоор хүлээн авсан, эмийн үлдэгдэл өмнөх оноос 1,298.9 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалт хийгдсэнээс шалтгаалсан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 10,700.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж хүлээн авч, батлагдсан төсвөөс 5,939.9 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан байна.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 380,666.3 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 319,043.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 287,673.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгээр, 19,889.3 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, 11,480.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 292,182.5 мянган төгрөг буюу 91,6 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 500,0 мянган төгрөгийг ахмад настны сувилал ажиллуулахад, 300,0 мянган төгрөгийг хүүхдийн сувилал ажиллуулахад, 45,4 мянган төгрөгийг сүрьеэгийн сорьц тээвэрлэхэд, эрүүл мэндийн тусгай зориулалтын сангаас 380,0 мянган төгрөгийг өдрийн эмчилгээний санхүүжилт авч нэмэлт төсөв бүрдүүлсэн байна. Олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 63,235.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 6,392.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,840.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 56,843.2 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 816,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Үүнд:

1. Тайлант хугацааны эцэст 1,840.4 мянган төгрөгийн шатахуун /талон / нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 43.5. Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Эмийн худалдан авалтыг тендер зарлаагүй шууд хийсэн бөгөөд Эмийн эргэлтийн сангаас 2320,2 мянган төгрөгөөр нэмэгдэлтэй үнээр эм нийлүүлсэн нь ТБОНӨХБҮХАТ хуульд нийцэхгүй бөгөөд үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв .

3. Ерөнхий журналын бичилтүүдийг бүхэлд нь шалгаж үзсэнээс алдаатай байх магадлалтай 35 ажил гүйлгээний журналын бичилтийг шалгахад 20 гүйлгээ буюу 14,856.1 мянган төгрөг бөгөөд 92,3% нь эмийг бараа материалын тайланд огт орлого авахгүй тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардлын дансанд бичсэн нь аудитын үнэн зөв байх, иж бүрэн байх, бодитой оршин байх ба тохиолдсон байх, батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 26.1."Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны заавартай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв .

4. Тайлант хугацаанд 76,633.6 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан боловч эдгээрээс 40,660.6 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ нь Е-баримттай байна. 35,973.0 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчсөн эсэхийг анхан шатны баримтаас түүвэрлэн шалгахад шатахууныг зарцуулах нормоос 498,0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байгаа нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаалын хэрэгжилтийг хангахгүй бөгөөд үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

6. Анхан шатны баримтаас түүвэрлэн шалгахад гэрэл цахилгааны зардлаас 539.5 мянган төгрөгийн материал бэлтгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын гол асуудал буюу залруулагдаагүй алдаа зөрчил

- Тайлант хугацаанд хийгдсэн 55,157.6 мянган төгрөгийн гүйлгээг төрийн сангийн мэргэжилтэн гарын үсэг зурж баталгаажуулаагүй, мөн 2,134,1 мянган төгрөгийн 1-р гарын үсэггүй, байгууллагын тамгагүй төлбөрийн хүсэлтээр төрийн сан гүйлгээ хийсэн зөрчлүүд илэрсэн. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэсэн заалтыг зөрчиж байгаа бөгөөд санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
- Тайлант онд 400,287.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн 4 дүгээр улирлын элэгдлийг тооцоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4. дэх

“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.6. дахь “бүх зардал;”, УСНББОУС 3.66-д “Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр элэгдүүлнэ” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн 816,0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 142,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 төлбөрийн актыг төлж хэрэгжүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн аудитын гол асуудалд дурдагдсан залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. МУЕА-аас өгсөн чиглэлийн дагуу суудлын автомашины ашиглалтын талаар

1.1 Илрүүлэлт: Анхан шатны баримыг түүвэрлэн шалгахад гэрэл цахилгааны зардлаас 539.5 мянган төгрөгийн материал бэлтгэсэн байна.

1.1. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулагдах, төсвийн сахилга бат зөрчих.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” хэрэгжүүлэх.

1.2. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

СТ-1А

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Давсны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19088174.15	24081045.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19088174.15	24081045.68
351	Түүхий эд материал	752255.15	2356581.68
35110	Тусгай зориулалттай материал	478318.00	478318.00
35130	Эм боох материал	273937.15	1878263.68
354	Хангамжийн материал	17978919.00	21213464.00
35410	Бичиг хэргийн материал	134880.00	763980.00
35420	Аж ахуйн материал	1135050.00	837000.00
35440	Түлш, шатах тослох материал	1209900.00	1329360.00
35460	Хүнсний материал	78530.00	337100.00
35470	Бусад хангамжийн материал	15420559.00	17946024.00
35500	Биологийн хөрөнгө	357000.00	511000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	351549400.58	356585320.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	351549400.58	356585320.89
392	Биет хөрөнгө	315549400.58	320585320.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	256203666.63	256203666.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-3543636.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33506834.00	33506834.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8726472.36	-12443526.63
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55497176.00	70637076.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24448325.20	-28163752.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14651850.00	16151850.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11342003.65	-11814858.55
39209	Зам, гүүрийн байгууламж	4428400.00	4428400.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-4221724.84	-4376731.12
393	Биет бус хөрөнгө	36000000.00	36000000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36000000.00	36000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	370637574.73	380666366.57
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	370637574.73	380666366.57
51	Засгийн газрын хувь оролцоо	370637574.73	380666366.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	294572263.12	294572263.12
51101	Өмч: - төрийн	258572263.12	258572263.12
51103	- хувьцаат	36000000.00	36000000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-26782031.60	-16753239.76
51210	Өмнөх үеийн үр дүн	-26782031.60	-26782031.60
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	10028791.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102847343.21	102847343.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	370637574.73	380666366.57

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	235,632,200.0	332,060,733.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
110	Орлогын албан татвар	0.00	0.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	17,092,233.2
120	Нийтлэг татварын бус орлого	-	17,092,233.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	17,092,233.2
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	17,092,233.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	235,632,200.0	314,968,500.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	235,500,500.0	293,239,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	235,500,500.0	293,239,400.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,700.0	1,225,400.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,213,400.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	131,700.0	12,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	11,480,900.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	11,480,900.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	9,022,800.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	9,022,800.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	245,348,385.2	322,031,941.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,348,385.2	322,031,941.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229,471,027.3	306,036,384.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,283,002.5	19,718,902.7
210502	Хоол, хүнс	5,515,570.0	6,774,980.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	251,550.0	1,197,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,499,381.0	8,553,900.0
210604	Урсгал засвар	1,499,381.0	8,553,900.0
2107	Томилолт, зочны зардал	761,400.0	2,481,900.0
210702	Дотоод албан томилолт	761,400.0	2,481,900.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,970,686.5	11,274,190.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,563,686.5	10,677,350.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	210,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	111,000.0	87,840.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,100.0	26,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,500.0	33,000.0
210807	Газрын төлбөр	14,400.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	190,000.0	240,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,179,756.7	17,988,979.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,644,875.0	6,385,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,644,875.0	6,385,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,500.0	33,000.0
210807	Газрын төлбөр	14,400.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	190,000.0	240,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,179,756.7	17,988,979.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,644,875.0	6,385,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,534,881.7	11,603,979.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,877,357.9	15,995,557.1
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15877357.86	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15877357.86	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15,995,557.1
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,995,557.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(9,716,185.2)	10,028,791.8
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(9,716,185.2)	10,028,791.8

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл Мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,715,378.0	189,237,209.6
210101	Үндсэн цалин	106,525,378.0	182,991,573.6
210102	Нэмэгдэл	17,028,000.0	3,015,717.0
210104	Урамшуулал	11,162,000.0	3,229,919.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,325,874.7	21,801,171.0
210201	Тэтгэврийн даатгал	10,828,374.7	15,305,877.9
210202	Тэтгэмжийн даатгал	1,374,200.0	1,460,270.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,099,800.0	1,360,795.8
210204	Ажилгүйдлийн даатгал	274,700.0	334,021.6
210205	Эрүүл мэндийн даатгал	2,748,800.0	3,340,205.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,412,098.0	10,420,010.9
210301	Гэрэл, цахилгаан	1,499,298.0	2,059,784.0
210302	Түлш, халаалт	8,752,400.0	8,090,226.9
210303	Цэвэр, бохир ус	160,400.0	270,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,556,330.0	16,587,640.0
210401	Бичиг хэрэг	1,151,650.0	1,443,270.0
210402	Тээвэр, шатахуун	9,009,070.0	11,369,340.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	814,600.0	923,300.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, арнутгал	1,198,000.0	2,008,700.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	383,010.0	843,030.0
2105	Нормативт зардал	16,050,122.5	27,691,382.7

4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СТ-2А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	235,632,200.0	314,968,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	235,632,200.0	314,968,500.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	235,500,500.0	293,239,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	235,500,500.0	293,239,400.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,700.0	1,225,400.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	131,700.0	1,225,400.0
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	11,480,900.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	11,480,900.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	9,022,800.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	9,022,800.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	234,632,200.0	314,968,500.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	234,632,200.0	314,968,500.0

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	218,754,842.1	298,972,942.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,715,378.0	178,570,279.6
210101	Үндсэн цалин	106,525,378.0	151,884,925.6
210102	Нэмэгдэл	17,028,000.0	16,873,592.0
210104	Урамшуулал	11,162,000.0	9,811,762.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,325,874.7	22,755,418.9
210201	Тэтгэврийн даатгал	10,828,374.7	15,397,334.4
210202	Тэтгэмжийн даатгал	1,374,200.0	1,963,533.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,099,800.0	1,545,338.0
210204	Ажилгүйдлийн даатгал	274,700.0	349,928.5
210205	Эрүүл мэндийн даатгал	2,748,800.0	3,499,284.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,769,098.0	11,480,210.9
210301	Гэрэл, цахилгаан	1,499,298.0	2,059,784.0
210302	Түлш, халаалт	9,109,400.0	9,060,426.9
210303	Цэвэр, бохир ус	160,400.0	360,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,279,749.0	16,444,200.0
210401	Бичиг хэрэг	1,148,600.0	1,922,320.0

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл Мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	9,947,650.0	10,764,400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	968,600.0	923,300.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,198,000.0	1,617,100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,016,899.0	1,217,080.0
2105	Нормативт зардал	16,414,000.0	22,905,546.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,208,900.0	14,814,996.1
210502	Хоол, хүнс	5,594,100.0	7,033,550.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	611,000.0	1,057,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,729,381.0	16,956,765.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,230,000.0	6,902,865.0
210602	Тавилга	-	1,500,000.0
210604	Урсгал засвар	1,499,381.0	8,553,900.0
2107	Томилолт, зочны зардал	761,400.0	2,481,900.0
210701	Гадаад албан томилолт	-	710,000.0
210702	Дотоод албан томилолт	761,400.0	1,771,900.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,000,686.5	21,013,622.4

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,563,686.5	20,390,032.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	210,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	111,000.0	87,840.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,100.0	52,750.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,500.0	33,000.0
210807	Газрын төлбөр	14400.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	220,000.0	240,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,759,275.0	6,365,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,759,275.0	6,365,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,877,357.9	15,995,557.1
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,877,357.9	15,995,557.1
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,877,357.9	15,995,557.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1000000.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1000000.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1000000.00	0.00

4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН СТ-4А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	-26,782,031.60	0.00	370,637,574.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	-26,782,031.60	0.00	370,637,574.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	-26,782,031.60	0.00	370,637,574.73
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	-26,782,031.60	0.00	370,637,574.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	-26,782,031.60	0.00	370,637,574.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Галаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,028,791.84	0.00	10,028,791.84
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	-16,753,239.76	0.00	380,666,366.57

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235500500.00	219623142.14	324610100.00	297747542.87
УРСГАЛ ЗАРДАЛ	235500500.00	219623142.14	324610100.00	297747542.87
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235500500.00	219623142.14	324610100.00	297747542.87
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147076000.00	134715378.00	202058800.00	178570279.63
Үндсэн цалин	111084000.00	106525378.00	160539300.00	151884925.63
Нэмэгдэл	24830000.00	17028000.00	22193200.00	16873592.00
Урамшуулал	11162000.00	11162000.00	19326300.00	9811762.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17653300.00	16325874.69	25257400.00	22755418.90
Тэтгэврийн даатгал	11770100.00	10828374.69	17174500.00	15397334.40
Тэтгэмжийн даатгал	1470700.00	1374200.00	2020500.00	1963533.36
ҮОМШӨ-ний даатгал	1176900.00	1099800.00	1616400.00	1545337.95
Ажилгүйдлийн даатгал	294000.00	274700.00	404400.00	349928.53
Эрүүл мэндийн даатгал	2941600.00	2748800.00	4041600.00	3499284.66
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10827700.00	10769098.00	11480900.00	11480210.93
Гэрэл, цахилгаан	1721900.00	1499298.00	2075000.00	2059784.00
Тулш, халаалт	8945400.00	9109400.00	9045400.00	9060426.93
Цэвэр, бохир ус	160400.00	160400.00	360500.00	360000.00
Хангамж, бараа материалын зардал	14159500.00	14148049.00	16438600.00	16398800.00
Бичиг хэрэг	1150000.00	1148600.00	1950000.00	1922320.00
Тээвэр, шатахуун	9819400.00	9815950.00	10719400.00	10719000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	973000.00	968600.00	934000.00	923300.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1217100.00	1198000.00	1617100.00	1617100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1000000.00	1016899.00	1218100.00	1217080.00
Нормативт зардал	16414900.00	16414000.00	22526400.00	22525546.05
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10208900.00	10208900.00	14538200.00	14434996.05
Хоол, хүнс	5594100.00	5594100.00	7034400.00	7033550.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	611900.00	611000.00	953800.00	1057000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	3736500.00	3729381.00	16959000.00	16956765.00
Багаж, техник, хэрэгсэл	1236500.00	1230000.00	6903000.00	6902865.00
Тавилга	1000000.00	1000000.00	1500000.00	1500000.00
Урсгал засвар	1500000.00	1499381.00	8556000.00	8553900.00
Томилолт, зочны зардал	841600.00	761400.00	2883100.00	2481900.00
Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00	710000.00
Дотоод албан томилолт	841600.00	761400.00	2883100.00	1771900.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19224900.00	18000686.45	21439900.00	21013622.36
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18787900.00	17563686.45	20660000.00	20390032.36
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00	268000.00	210000.00
Даатгалын үйлчилгээ	111000.00	111000.00	138000.00	87840.00
Тээврийн хэрэгслийн татвар	64100.00	64100.00	48500.00	52750.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	27500.00	27500.00	66000.00	33000.00
Газрын төлбөр	14400.00	14400.00	14400.00	0.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	220000.00	220000.00	245000.00	240000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5566100.00	4759275.00	5566000.00	5565000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5566100.00	4759275.00	5566000.00	5565000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	324610100.00	0.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	293239400.00	0.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	0.00	293239400.00	0.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	11480900.00	0.00
Орон нутгийн төсвөөс	0.00	0.00	11480900.00	0.00
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	19889800.00	0.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00	19889800.00	0.00